



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Н. Батзул
Утас: 98111917
Цахим хаяг: batzuln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ДАРВИ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.ХАЙДАВ ТАНАА**

2025.03.25 № 2/124
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, НББ-ын тухай хуулийн 20.2.5 дугаар заалт, Зээлийн гэрээний 2.4 дүгээр заалт, 3.3.2 дугаар заалт, 10.1 дүгээр заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дугаар заалт, Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.3.2 дугаар заалт, 10.1 дүгээр заалтуудтай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, 69,100.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн зээлд 50,535.7 мянган төгрөгний хүү алданги тооцох байсан тооцоогүй, зээл авсан иргэд зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсхэд хяналт тавиагүй, зээлийн эргэлт удааширч байхад эргэн төлүүлэх арга хэмжээ аваагүй, дараагийн зээл авах иргэдийн боломж алдагдсан.
- Гэрээт ажлын баталгааны 5 хувь болох 2,235.0 мянган төгрөг суутгаж үлдээгүй
- Тайлант хугацаанд Орон нутаг хөгжлийн сангаас гарсан 8,500.0 мянган төгрөгийн ажил гүйлгээнд анхан шатны баримт бүрдэлт дутуу

Асуудлыг онцолсон хэсэг

Дарви сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 3,013.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 514.0 мянган төгрөгөөр буюу 20.6 хувиар давуулан биелүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу, эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,861,025.80	3,575,635.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,024,744.00	2,093,058.60
33	АВЛАГА	743,130.40	1,376,091.00
35	БАРАА МАТЕРИАЛ	93,151.40	106,485.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,233,582.20	4,299,765.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,233,582.20	4,299,765.30
39200	Биет хөрөнгө	3,201,649.80	4,268,787.80
39300	Биет бус хөрөнгө	31,932.50	30,977.50
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,094,608.00</u>	<u>7,875,400.70</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	155,170.70	106,508.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	155,170.70	106,508.00
41300	Өглөг	155,170.70	106,508.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,939,437.30	7,768,892.80
51	Засгийн газрын хувь оролцоо	5,939,437.30	7,768,892.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	662,858.90	662,858.90
51200	Хуримтлагдсан үр дүн	4,957,896.70	6,787,352.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,681.70	318,681.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,094,608.00</u>	<u>7,875,400.70</u>

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>4,526,982.70</u>	<u>7,800,430.90</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,775,231.40	3,001,815.40
110	Орлогын албан татвар	1,407,737.90	2,330,442.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,427,003.50	2,355,011.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,265.60	-24,569.90
113	Хөрөнгийн албан татвар	108,866.00	125,522.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	258,627.50	545,851.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,079,937.50	3,239,599.20
120	Нийтлэг татварын бус орлого	2,079,937.50	3,239,599.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	671,813.80	1,559,016.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,279,297.20	5,970,825.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,279,297.20	5,970,825.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,031,518.20	5,032,481.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,888.80	791,807.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,223.10	93,875.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,751.80	483,676.20
2104	Хангамж, бараа материалын зардал	1,413,535.10	2,176,508.30
2105	Нормативт зардал	176	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,591.30	13,649.10
2107	Томилолт, зочны зардал	8,539.10	12,018.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	473,662.10	339,795.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	554,150.70	1,121,151.70
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	247,779.10	938,344.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,247,685.50	1,829,605.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,247,685.50	1,829,455.50

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,175,782.90	6,353,718.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,775,231.40	3,001,815.40
110	Орлогын албан татвар	1,407,737.90	2,330,442.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,427,003.50	2,355,011.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,265.60	-24,569.90
113	Хөрөнгийн албан татвар	108,866.00	125,522.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	258,627.50	545,851.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,192.00	11,227.60
1181	Газрын төлбөр	245,829.40	531,981.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,606.00	2,642.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,250,285.80	1,800,303.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,250,285.80	1,800,303.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,150,265.70	1,551,599.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,018,611.60	3,453,725.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,018,611.60	3,453,725.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,318,537.00	2,514,313.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	491,301.20	839,428.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,831.40	102,547.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,255.00	500,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,477.50	47,039.90
2105	Нормативт зардал	502.3	853.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,735.90	15,996.30
2107	Томилолт, зочны зардал	8,618.30	11,526.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	445,469.20	414,351.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,346.30	582,312.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,700,074.70	939,412.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,157,171.30	2,899,992.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,628,150.80	2,831,528.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,628,150.80	2,831,528.30

2200	Дотоод эх үүсвэрээр	1,628,150.80	2,831,528.30
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,628,150.80	-2,831,528.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100	-150
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100	150
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	528,920.50	68,314.50
101	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	<u>1,495,823.60</u>	<u>2,024,744.00</u>
20	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	<u>2,024,744.00</u>	<u>2,093,058.60</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,691,751.8	0.0	4,691,751.8
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,691,751.8	0.0	4,691,751.8
3	Тайлант үеийн үр дүн	1,247,685.5	0.0	1,247,685.5
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,939,437.3	0.0	5,939,437.3
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,939,437.3	0.0	5,939,437.3
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,939,437.3	0.0	5,939,437.3
8	Тайлант үеийн үр дүн	1,829,455.5	0.0	1,829,455.5
9	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,768,892.8	0.0	7,768,892.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 134,806.3 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснээс аудитын явцад 4,435.0 мянган төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн. Үүнд:

- ✓ ХХС-ийн Авлагын эцсийн үлдэгдлийг программаас буруу тооцож гарган санхүүгийн тайланд тусгахдаа 4,435.0 төгрөгөөр буруулж, ӨӨТ-н бодлогын өөрчлөлт дээр тавьж өмнөх оны үр дүнг өөрчилсөн. Аудитаар нийт залруулагдаагүй 130,371.3 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 130,371.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мян төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	1	4,435.0			1	4,435.0	1	4,435.0		
Дүн	1	4,435.0	-	-	1	4,435.0	1	4,435.0	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мян төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Барилгын засвар болон шинээр хийгдсэн гэрээт ажлын баталгааны 5 хувийг тус тус суутгаагүй.	1	2235.0					1	2235.0
Санхүүгийн ажил гүйлгээнд ажилын гэрээ болон санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу	1	8500.0					1	8500.0
Авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актгүй, Хугацаа хэтэрсэн зээлд гэрээний дагуу хүү, алданги тооцоогүй.	1	119,636.3					1	119,636.3
Дүн	3	157,395.45					3	157,395.45

4.3 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Байгууллагын нэр	Аудитад хамрагдвал зохих	Хамрагдсан	Байгууллагын тоо		Аудитын санал дүгнэлтийн төрөл			
			Гүйцэтгэсэн		үүнээс			
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Зөрчилгүй	Хязгаар лалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
ИТХ	1	1		1				
ЗДТГ	1	1	1			1		
Хоршоо хөгжүүлэх сан	1	1		1				
Орон нутгийн хөгжлийн сан	1	1		1			-	-
НИЙТ	4	4	-	3	-	1	-	-